**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/103 Мөрөн сум

Дипломат, гадаад албан паспорт
олгох хүсэлт уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам" -ын 2.2.2, 3.7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Я.Эрхэмбаяр нь 2023 оны 04 сарын 04-нөөс 6-ны өдрийн хооронд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Түндэмүн дүүрэгт зохион байгуулагдах "Монголд үйлдвэрлэв 2023" үзэсгэлэн худалдаанд оролцох болсонтой холбогдуулан албан паспорт олгуулах хүсэлтийг Гадаад харилцааны яаманд уламжилсугай.

2. Гадаад улсад албан томилолтоор ажилласан тухай бүртээ холбогдох мэдээллийг илтгэх хуудсаар аймгийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010453